

**ЕРӨНХИЙ ЭРДМИЙН БАГШИЙН АЖЛЫН
БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр

Нэгжийн нэр

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж	Сураглтын алба
Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл
ЕЭ-ийн багшийн албан тушаалын нэр:	Төрийн үйлчилгээний албан хаагч ТҮМБ-4
Ерөнхий эрдмийн багш	
Ажлын цаг	Ажлын байрны албан ёсны байршил
8 цаг	ГСА 3-р баг
Хөдөлмөрийн нөхцөл	Онцгой нөхцөл
Хэвийн	Шаардлагатай үед илүү цагаар ажиллах Ажлын шаардлагаар амралт, баяр ёслолын өдрүүдэд ажиллах

1. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Ажлын байрны зорилго: Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн агуулгын хэрэгжилтийн суурь болох ерөнхий боловсролын стандартыг хангах төвшинд суралцагчдад боловсрол эзэмшүүлж тэднийг зөв төлөвшил, хүмүүжил, хөгжилтэй иргэн болгох үйл явцыг сурган хүмүүжүүлэх үндэстэй удирдан чиглүүлэх

Албан тушаалын зорилт: Ажлын байрны зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааг биелүүлэх, хариуцлагатай хандах, шударга, бусдын нөлөөнд автахгүй байх, ёс зүйг эрхэмлэдэг, албан байгууллагын төлөө гэсэн мэрийлт чин сэтгэлтэй байх, байгууллагын болон хувь хүний нууцыг чанд хадгалах, хариуцлага хүлээх чадвартай байх, удирдлагаас өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлэх, ёс зүйн зөрчилгүй, суралцагчдын сургах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх, төлөвшүүлэх, багшийн хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэх, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай хууль, МБС-ын тухай хууль, ХАБЭА тухай хууль, харъяа яам болон бусад байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, санал зөвлөмжийг биелүүлэх, ажлын байрны шалгуур, шаардлагыг хангах, холбогдох бодлогын баримт бичгүүдийг мөрдөн хэрэгжүүлж ажиллах, хөдөлмөрийн гэрээ, сургуулийн хөдөлмөрийн дотоод журам бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.

Танилцсан:


Гарын үсэг

М.Монгол

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж-2019

нийгмийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, өмч хөрөнгийг зориулалтаар нь ашиглан ажиллана.


Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага тогтолцооны хэлбэр
<p>Зорилт-1: Суралцагчдад мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий боловсролын стандартыг олон талын оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх</p>	<p>Ажлын байрны 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд: 1.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын хөтөлбөрөөр суралцагчдын ерөнхий боловсрол эзэмших сургалтын хэрэгцээ, боломжийг судлах; 1.2.Ерөнхий эрдмийн сургалтын агуулгыг суралцагчдын эзэмших мэргэжил, мэргэжлийн болон техникийн боловсролын зорилгод нийцүүлж хэрэглээний агуулгаар баяжуулах; 1.3.Мэргэжлийн болон техникийн боловсрол дахь ерөнхий эрдмийн хичээлийн агуулгыг суралцагчдын хүлээн авах боллоцоонд нийцүүлэн элементарчлах; 1.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын ерөнхий эрдмийн хичээлийн хөтөлбөрийг боловсруулах; 1.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын ерөнхий эрдмийн багшийн сургах хөдөлмөр нь суралцагчийн сэтгэхүйн үйлдэл хийхээс чадамжийн үйлдэл хийх арга зүйд тулгуурласан байх; 1.6.Сургалтын үндсэн баримт бичгүүдийг (сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, ээлжит хичээлийн төлөвлөгөө гэх мэт) боловсруулах, боловсронгуй болгох ажилд мэргэжлийн үүднээс хандаж, бүтээлчээр ажиллах;</p>	<p>Ерөнхий эрдмийн сургалтын агуулгыг шинжлэх ухааны хувьд алдаагүйгээр элементарчилж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг эзэмшихэд шаардлагатай ерөнхий боловсролыг эзэмшүүлсэн байна.</p>	<p>Хариуцан гүйцэтгэх</p>
<p>Зорилт-2: Мэргэжлийн болон техникийн боловсролын ерөнхий эрдмийн сургалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, оношлох</p>	<p>Ажлын байрны 2 дугаар үндсэн зорилтын хүрээнд: 2.1.Ээлжит хичээлийн төлөвлөлт боловсруулах; 2.2.Суралцагчдыг сурах үйлд чиглүүлэн удирдах; 2.3.Хичээлийн интеграци хийх; 2.4.Суралцах үйл ажиллагааг дэмжихүйц орчин бүрдүүлэх; 2.5.Хичээлд тавих ерөнхий</p>	<p>Ерөнхий эрдмийн сургалтын агуулгыг мэргэжлийн болон техникийн сургалтын зорилгыг дэмжихүйцээр боловсруулсан байна.</p> <p>Бусад төвшний сургалтын байгууллагын ерөнхий эрдмийн хичээлийн</p>	<p>Хариуцан гүйцэтгэх</p>

Танилцсан:
Гарын үсэг 


	<p>шаардлагыг хангах; 2.6.Хичээлийн шинжлэх ухаанч байх шаардлагыг биелүүлэх; 2.7.Хичээлд оролцогчдын сэтгэл зүйн бэлтгэлийг хангах; 2.8.Хичээлд тавигдах дидактик шаардлагыг шаардлагыг хангаж ажиллах; 2.9.Сургалтын үр дүнд тасралтгүй үнэлгээ хийх; 2.10.Ерөнхий эрдмийн гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах; ; Нэмэлт хичээл, давтлага өгөх;</p>	<p>агуулгын залгамж холбоог хангасан байна. Хичээлийн зохион байгуулалт, арга зүй нь суралцагчдын арга барил, хэрэгцээ, сонирхолд нийцсэн байна. Ерөнхий эрдмийн сургалтын үр дүн нь тасралтгүй үнэлэх, оношлох боломжоор хангагдсан байна.</p>	
<p>Зорилт-3: Хувьсан өөрчлөгдөж буй орчинд ажиллах, амьдрах чадвартай, зөв төлөвшил, хөгжил хүмүүжилтэй, нийгмийн хариуцлагатай иргэнийг бэлтгэн гаргахад идэвхтэй оролцох</p>	<p>Ажлын байрны 3 дугаар үндсэн зорилтын хүрээнд: 3.1.Удирдсан ангийн болон хичээл заадаг ангийн сурагчдын талаар судалгаа хийж (сонирхол хэрэгцээ, сурах үр чадвар, амьдралын орчин, эрүүл ахуйн боловсрол гэх мэт) түүнд тулгуурлан ажилладаг байх; 3.2.Суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран ажилладаг байх; 3.3.Суралцагчдын бүтээлч сэтгэлгээг дэмжин ажилладаг байх; 3.4.Суралцагчдын өөрийгөө илэрхийлэх, бие даан ажиллах чадварыг хөгжүүлдэг байх; 3.5.Суралцагчдын урлагийн авьяас чадварыг нээн, хөгжүүлдэг байх; 3.6.Суралцагчдын спортыг авьяас чадварыг нээн хөгжүүлдэг байх; 3.7.Суралцагчдыг ерөнхий эрдмийн хичээлийн олимпиад, уралдаан, тэмцээнд бэлтгэн оролцуулдаг байх; 3.8.Суралцагчдад ажиллах, амьдрах ухааны арга барилд дэмжлэг үзүүлэх; 3.9.Хүүхэд, залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход нь туслалцаа үзүүлдэг байх; 3.10.Суралцагчдыг нийгэмшүүлэх тэдний хөгжил, төлөвшил, нийгмийн асуудлаар сургуулийн нийгмийн ажилтантай хамтран ажилладаг байх;</p>	<p>Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад хамрагдагсдын судалгааг сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлалын ухааны үндэслэлтэй хийж тэдний хөгжил, төлөвшлийг хангахад боловсрол судлалын арга зүйн үүднээс хандаж сургалтын байгууллага, багш нарт мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна.</p>	<p>Хариуцан гүйцэтгэх</p>

Танилцсан: _____
Гарын үсэг _____

	<p>3.11.Суралцагчдын хөгжил, хүмүүжлийн асуудлаар хүүхэд залуучууд, хүүхэд хамгаалах байгууллагуудтай хамтран ажилладаг байх;</p>		
<p>Зорилт-4: Олон янзын соёл, хүмүүсийн нэгдлээс бүрдсэн нийгэмд амьдрах, бие даан тасралтгүй сурах суралцахуйн орчинг сургуульд бүрдүүлэх</p>	<p>Ажлын байрны 4 дүгээр үндсэн зорилтын хүрээнд: 4.1.Сургуулийн орчинд суралцагчдын суралцах үйлийг дэмжсэн сэтгэл зүйн орчин бүрдүүлэх ажлыг мэргэжлийн үүднээс зохион байгуулах. Үүнд: 4.2.Сургуулийн хүрээнд багш-суралцагчид, суралцагч хоорондын харилцаа, хандлагын зөв орчинг бүрдүүлэх ажлыг мэргэжлийн үүднээс зохион байгуулах; 4.3.Багаар ажиллах, ажиллах-амьдрах ухааны зөв төлөвшил олгоход мэргэжлийн туслалцаа үзүүлж ажиллах; 4.4.Бие дааж тасралтгүй суралцах хэрэгцээ, сонирхлыг төрүүлэх ажлыг суралцагчдын дунд зохиох; 4.5.Суралцагчдын суралцах үйлийг дэмжсэн материаллаг орчин бүрдүүлэхэд мэргэжлийн үүднээс хандаж туслалцаа үзүүлэх. Үүнд: 4.6.Сургалтын үйлчилгээг хангасан ном, сурах бичиг, гарын авлагын санг бүрдүүлж ашиглах; 4.7.Сургалтын хөтөлбөрийн үр дүнг үнэлэх үнэлгээний санг бүрдүүлж үр дүнтэй ашиглах; 4.8.Сургалтад үзүүлэн, тарааж өгөх материалыг өргөн ашиглаж, хүртээмжийг нэмэгдүүлэх; 4.9.Сургалтад дэвшилтэт технологи, цахим хэрэглэгдэхүүнийг өргөн ашиглах; 4.10.Сургалтын баримт бичгүүдийг хөтлөх (журнал, сурагчийн хувийн хэрэг гэх мэт);</p>	<p>Хамтарч амьдрах соёлын орчин, бусдын эрх ашгийг хүндэтгэх орчин, зөв амьдрах, ажиллах ухааны орчин, бие даан тасралтгүй суралцах орчинг бүрдүүлсэн байна</p>	<p>Хариуцан гүйцэтгэх</p>
	<p>Ажлын байрны 5 дугаар үндсэн зорилтын хүрээнд: 5.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг боловсруулах, боловсронгуй болгоход ЕБС, боловсролын дээд төвшний байгууллагуын</p>		

Танилцсан:
 Гарын үсэг 


<p>Зорилт-5: Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад олон нийт, боловсролын болон нийгмийн түншлэлийн оролцоог идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<p>мэргэжлийн туслалцаа авах ажлыг зохион байгуулах; 5.2.Ижил төвшний МБС-ын байгууллагын хамтын оролцоотойгоор ерөнхий эрдмийн хичээлийн агуулга, сургалтын арга зүй технологийг боловсронгуй болгох чиглэлээр хамтарч ажиллах; 5.3.Бүсийн арга зүйн төвийн мэргэжлийн дэмжлэгтэйгээр ерөнхий эрдмийн хичээлийн технологийг боловсронгуй болгох чиглэлээр хамтарч ажиллах; 5.4.Бусад сургалтын байгууллагатай хамтарч багш солилцооны хөтөлбөрт хамрагдах; 5.5.Ерөнхий эрдмийн хичээл заалтыг боловсронгуй болгох, сайн туршлагаас суралцах, түгээн дэлгэрүүлэхэд оролцох; 5.6.Сургуулийн эцэг эхийн зөвлөлийн ажлыг идэвхжүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах; 5.7.Багш нарын өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг идэвхтэй дэмжин ажиллах; 5.8.Удирдах зөвлөлөөр дамжуулан сургуулийг удирдахад санаачилгатай оролцох;</p>	<p>Мэргэжлийн болон техникийн боловсролын ерөнхий эрдмийн сургалтын агуулга, судлах арга зүйг сонирхогч талууд, тэрчлэн боловсролын бүх төвшний байгууллагуудын оролцоотой боловсронгуй болгох, улмаар ажил олгогч, олон нийтийн байгууллага, эцэг эх, сургуулийн удирдах зөвлөлийн ажиллагааг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.</p>	<p>Хариуцан гүйцэтгэх</p>
<p>Зорилт-6: Багш өөрийгөө чадавхижуулах, мэргэжлийн болон техникийн боловсролын судалгаа, хөгжил, инновацийг дэмжих, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд идэвхтэй оролцох</p>	<p>Ажлын байрны 6 дугаар үндсэн зорилтын хүрээнд: 6.1.Багш нарын дунд зохиогддог төрөл бүрийн уралдаан, тэмцээнд идэвхтэй оролцох; 6.2.Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай суралцах; 6.3.Багш өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах; 6.4.Багш боловсролын болон мэргэжлийн зэргээ ахиулах хүсэл эрмэлзэлтэй ажиллах; 6.5.Боловсролын хууль тогтоомж, сургуулийн хэмжээнд мөрддөг дүрэм, журмыг судалж хэрэгжүүлдэг байх; 6.6.Гадаад хэлний мэдлэгээ ахиулах; 6.7.Мэдээллийн технологийг сургалтад ашиглах чадвараа</p>	<p>Багш өөрийгөө хөгжүүлэх зорилго, төлөвлөгөөтэй, сургалт судалгааны ажилд идэвхтэй оролцдог, байгууллагын хөгжлийн бодлого, инновацийн зорилтыг тодорхойлж түүнийг идэвхтэй хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Хариуцан гүйцэтгэх</p>

Танилцсан:
 Гарын үсэг 

	<p>нэмэгдүүлэх; 6.8.Сургах, сурах үйлийн судалгаа хийж түүнд тулгуурлан ажлаа төлөвлөж хэрэгжүүлдэг байх 6.9.Сургалтын болон хүмүүжлийн ажлын дэвшилтэт үйл ажиллагааг судалж өөрийн ажилдаа хэрэгжүүлэх; 6.10.Сургууль, сургалтын үйлчилгээнд хэрэгжүүлж болох инновацийг бүтээх талаар идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлэх; 6.1.Сургуулийн үнэт зүйл, онцлогийг шингээсэн брэнд бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг бүтээж бий болгоход идэвхтэй оролцох; 6.12.Байгууллагыг хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд сургуультай нягт хамтран ажиллах;</p>	
1. Багш өөрийгөө чадавхижуулах, мэргэжлийн болон техникийн боловсролын судалгаа, хөгжил, инновацийг дэмжих, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд идэвхтэй оролцох	<p>Идэвх санаачилгатай ажиллах Өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэх; Албадуудаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх; Сургуулийн дүрэм, журамд тусгагдсан ажилтны ажил үүргийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх. Эрүүл ахуй, хөдөлмөр аюулгүй ажиллагааг ханган биелүүлэх; Бие даан мэргэжил боловсрол арга зүйгээ ажлын байран дээр байнга дээшлүүлэх; Сар бүр ажлын тайлан бичих, алба, бүх ажилчдын хуралд ажлаа тайлагнах.</p>	Хариуцан гүйцэтгэх

2. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр, түүнээс дээш зэрэгтэй
Мэргэжил	Багш Багшлах эрхтэй байх
Мэргэшил	Сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, багшлах үр ухаан, сурагчидтай ажиллах, удирдан зохион байгуулах арга барил эзэмшсэн байх Харилцааны үр чадвар, багаар ажиллах арга барил, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын удирдлага, арга зүй, технологийн сургалтад хамрагдсан байх
Туршлага	6 сараас доошгүй хугацаагаар дадлагажигч багшаар ажилласан туршлагатай байх ЕБС, бусад шатны сургуульд тухайн хичээлийг зааж байсан буюу дадлага хийсэн туршлагатай байх
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий эрдмийн хичээлийн төлөвлөлт, зохион байгуулалт, үнэлгээ хийх чадвартай байх - Суралцагчдыг идэвхжүүлэх, сонирхол төрүүлэх, сэдэл тэмүүлэл хандлага

Танилцсан:
 Гарын үсэг 

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж-2019

	<ul style="list-style-type: none"> - төлөвшүүлэх арга ухааныг эзэмшсэн байх - Бүтээлч, шинийг санаачлах, шинэчлэл өөрчлөлтийг мэдрэх чадвартай байх - Багшлах ажлын эв дүй, заах сургах, чиглүүлэх үр чадвартай байх - Гадаад хэлээр мэдээлэл авч ашиглах - Компьютерийн хэрэглээний програмуудыг эзэмшсэн байх - Мэдээлэл хүлээн авч боловсруулах - Судалгаа, шинжилгээ хийх, инновацийн хөгжлийг дэмжин оролцох - Шударга ёсыг дээдэлж, боловсролыг ардчилахад идэвхтэй оролцох - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх
--	--

3. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<p>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Захирал ХШҮДА мэргэжилтэн-1 Захиргаа, аж ахуй албаны менежер-1 Сургалтын албаны менежер-1 Хүний нөөцийн ажилтан-1 Арга зүйч-1 ХАБЭА ажилтан-1</p>
--

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдах албан тушаалын нэр, тоо: Оюутан суралцагчид-850</p>	<p>Бусад харилцах субъект</p> <ul style="list-style-type: none"> - МБС-ын бодлого зохицуулалтын газар, хэлтэс - МБС-ын үнэлгээний төв - Бүсийн арга зүйн төв - Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс - Ажил олгогч байгууллагууд - Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн зэрэг төрийн бус олон нийтийн байгууллагууд - Бүх шатны боловсролын байгууллагууд - Гадаад, дотоод төсөл хөтөлбөрийн нэгжүүд - Боловсролын судалгаа, шинжилгээ, арга зүйн байгууллагууд - Суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчид <p>Нийслэл, дүүрэг, хорооны нутаг дэвсгэрийн төр, захиргаа, аж ахуйн байгууллагууд</p>
--	--

5. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p>АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРУУЛСАН:</p>	<p>АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ ХЯНАЖ, БАТЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР:</p>
<p>Албан тушаал: <i>Мунг могоу</i> <i>Мунг могоу</i> (Гарын үсэг) (Эцэг эхийн нэр, өөрийн нэр) 2019 оны 09 дугаар сарын 09-ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: <i>ПТК</i> Шийдвэрийн огноо: <i>2019.08.29</i> Дугаар: <i>A/55</i></p>

Танилцсан:
 Гарын үсэг *Мунг могоу*


АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр: ПТК

Шийдвэрийн огноо: 2019.08.29

Дугаар: А/55

(Тамга/тэмдэг)



(Гарын үсэг)

У.Оймансүрэн

(Эцэг/эхийн нэр, өөрийн нэр)

2019 оны 09 дугаар сарын 09-ны өдөр

-----oO-----

Танилцсан:
Гарын үсэг mm